



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар A/14

Улаанбаатар хот

**Жендэрийн эрх тэгш байдлыг хангах
тухай хууль, тогтоомжийн
хэрэгжилтийг үнэлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Дүүргийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тогтоомж, дүүргийн дэд хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилтийг 96 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлсүгэй.

2.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тогтоомж, дүүргийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч, хэрэгжүүлж ажиллахыг дүүргийн Засаг дарга (А.Сүхболд)-д үүрэг болгосугай.

2.1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, арга хэмжээний төлөвлөгөөг хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хамт батлуулан ажиллах

2.2.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль, дүүргийн дэд хөтөлбөр арга хэмжээний төлөвлөгөөний зардлыг дүүргийн төсөвт тусган ажиллах

2.3.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тогтоомж, дүүргийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг жил бүр тайлагнах

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Зөвлөл, Хурлын Нийгмийн бодлогын хороонд тус тус даалгасугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ